

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашцэрэнгийн Далхжав	Дугаар	L076
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Батноров
Төрсөн газар	Хэнтий аймаг Батноров сум	Төрсөн он	1944
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Шадавчойнхорлин	Сүм хийдийн дугаар	ХЭБВ 106
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймаг Батноров сумын Шадавчойнхорлин хийд

-1934 онд Идэрмэг сум болсон юм байна. Хоёр хошуу нь Сэргэлэн гүн, Сүжигт бэйсийн хошуу юм байна тийм үү?

Тийм. Би хуучин Сэргэлэн гүний хошууны хүн. Энэ хошууны гол хийд нь Шадавчойнхорлин гэж байсан. Энэ баруунтай Төмстэй гэдэг уулын баруунтай. Одоо суурин дээр нь айл буучихсан.

-Лүнгийн хийд гэж ярьж байсан юм байна лээ?

Үгүй. Шадавчойнхорлин гэж байсан. Тахилгатай уул нь Идэрмэг уул. Идэрмэгбаян хан уул, Хутаг уул хоёр юм гэнэ лээ. Идэрмэгбаян хан уулын тахилгын сангийн судар нь түвд хэлэн дээр одоо байгаа юм. Гүллэнэ гэж зохионо гэсэн үг юм байгаа биз дээ?

-Хүсэх гэсэн үг.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэрэн дээр л Шадавчойнхорлингийн унзад гэлэн Агваансамдан гүллэсэн гэж байсан. Тэгээд би Шадавчойнхорлин гэж байсан гэдгийг мэдсэн.

Одоо энэ Сүжигт бэйсийн хүрээг Гэндэнлин гэдэг байсан гэсэн. Тэр цаадах Бат-Өлзийтийн энгэрт нэг байсан юм гэнэ лээ. Үзэмтийн хийд гэж яриад байгаа юм даа.

-Ялгуулсны хийд гэдэг үү?

Би сайн мэдэхгүй. Үзэмтийн гэж яриад байх шиг байдаг юм. Тийм л гурван хийд байсан гэж ярьдаг юм.

-Сүжигт бэйсийн хийдийн туурь маань суварга босгосныхоо хаана нь байх вэ?

Урд нь байна. Хундаамнаас урагшаа. Гол дуган нь хойшоо харсан байсан гэсэн.

-Яагаад хойшоо харсан хаалгатай хийсэн юм бол?

Тэрийг арай дууриасан юм биш байгаа. Сумын захиргаа байраа тэгж барьж байсан шүү.

-Аймаг дээрээс Лувсанжамц гуайн хүүхдэд хадгалагдаж байсан гар зургийг үзсэн.

Тэр Лувсанжамц гуай чинь Сүжигтийн хүрээний унзад байсан хүн. Сэргэлэн гүний хошуу, Сүжигт бэйсийн хошуу хоёр 1703 онд байгуулагдсан гэсэн.

-Энэ Сэргэлэн гүний хийд маань хэдэн онд байгуулагдсан бэ?

Хийдийг нь бол мэдэхгүй.Х ошуутайгаа нэг жил чадаагүй биз. Тэр багцаа байна биз дээ.

-Хэн гэдэг хүн байгуулсан юм бол?

Тэрийг мэдэхгүй. Яахав ноёдуудын нэр нь байгаа. Лам хуваргынх нь нэр байхгүй дээ.

-Хэдэн ламтай байсан юм бол?

Сэргэлэн гүний хийд цөөхөн. 70,80аад ламтай байсан гэсэн. Сүжигт нь арай томхон байсан байх.

-Өөр энэ гурван хийдийн талаар сонссон дуулсан юм юу байна?

Энэ манай ээж байгаа юм. Одоо 84 настай хөгшин байгаа юм. Ээж маань л мэднэ дээ. Хийд ямар байсан, тэр ном судар хийсэж байхыг нь мэддэг юм. Одоо энэ нутагт ээжийн дайны настай хүн байхгүй.